



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/152

Улаанбаатар хот

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн
дүрэм, зохион байгуулалтын бүтцийг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.2, 21.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.“Гэмтэл согог судлалын үндэсний төвийн дүрэм”-ийг нэгдүгээр, “Гэмтэл согог судлалын үндэсний төвийн зохион байгуулалтын бүтэц”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Гэмтэл согог судлалын үндэсний төвийн орон тоог 2026 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлж ажиллахыг Гэмтэл согог судлалын үндэсний төвийн захирал Э.Галбадрахад даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (С.Эрдэнэтуяа)-т үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/322 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


САЙД



Э.БАТШУГАР

141260774

Эрүүл мэндийн сайдын 2026 оны 04...
дүгээр сарын 22 -ны өдрийн А/52 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДҮРЭМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Гэмтэл согог судлалын үндэсний төв (цаашид “Төв” гэнэ) нь Монгол Улсын хэмжээнд гэмтэл, согог судлалын мэргэшсэн тусламж, үйлчилгээг үзүүлэх, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, бусад эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил, арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий лавлагаа төв мөн.
- 1.2 Төв нь Монгол Улсын хууль, тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.
- 1.3 Төв нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шууд удирдлагад харьяалагдан ажиллана.
- 1.4 Төв нь Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүд болон эрүүл мэндийн салбарын хөгжлийн бодлоготой уялдсан байгууллагын стратеги төлөвлөгөөг Эрүүл мэндийн сайдаар батлуулж хэрэгжүүлнэ.
- 1.5 Төв нь өөрийн харьяанд төрөлжсөн мэргэшлийн лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэх салбар эмнэлэгтэй байх бөгөөд салбар эмнэлгийн зохион байгуулалтын бүтэц энэхүү дүрмийн 9.29-д заасан бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулна.
- 1.6 Төвийн оноосон нэр: Гэмтэл согог судлалын үндэсний төв
 - Албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, 16094, Баянгол дүүрэг, 31 дүгээр хороо, Дилав хутагт Жамсранжавын гудамж;
 - Утас: 77115111
 - Салбар эмнэлгийн хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот 14192, Сүхбаатар дүүрэг, 7 дугаар хороо;
 - Утас: 77770136;
 - Цахим хуудасны хаяг: <https://www.gemtel.mn/>
 - Цахим шуудангийн хаяг: ncto@gemtel.moh.gov.mn
- 1.7 Төвийн нэрийг англи хэлээр “National Center for Traumatology and orthopedics” гэж орчуулна.
- 1.8 Төв нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, бэлгэдэл, туг, санхүүгийн харилцах данстай байна.
- 1.9 Тусгай хэрэгцээт иргэний эрхийг хүндэтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, мэдээлэл авах, бусадтай харилцахад шаардлагатай орчин нөхцөлийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хууль тогтоомжийн дагуу бүрдүүлсэн байна.

ХОЁР. ТӨВИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Алсын хараа: Гэмтэл, согогийн цогц тусламж, үйлчилгээгээр Азийн тэргүүлэх эмнэлгүүдийн нэг болно.

Эрхэм зорилго: Олон улсын жишигт нийцсэн гэмтэл, согогийн цогц тусламж, үйлчилгээг эрсдэлгүй, ээлтэй орчинд мэргэшсэн хамт олон тэгш, найрсаг үйлчилгээгээр хүртээмжтэй үзүүлнэ.

2.1 Төвийн зорилт:

- 2.1.1 Анагаах ухааны орчин үеийн дэвшилтэт технологийг үе шаттай нэвтрүүлж, үндэсний хэмжээнд болон төвийн үйл ажиллагаанд өргөнөөр ашиглана.
- 2.1.2 Гэмтэл, согогийг оношлох, эмчлэх, сувилах, хөнгөвчлөх, сэргээн засах цогц тусламж, үйлчилгээг Азийн тэргүүлэх улс орнуудтай өрсөлдөхүйц хэмжээнд хүргэнэ.
- 2.1.3 Өндөр ур чадвартай мэргэшсэн хүний нөөцийг тогтвор, суурьшилтай ажиллуулна.
- 2.1.4 Улсын хэмжээнд гэмтэл согогийн тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлж, тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлнэ.
- 2.1.5 Эрдэм шинжилгээний ажлын хэтийн болон ойрын зорилт, тэргүүлэх чиглэлийг тодорхойлж хийсэн судалгааны үр дүнг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллана.

2.2 Төв нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

- 2.2.1 Хууль, хүний эрхийг дээдлэх, ил тод байх, ээлтэй орчныг бүрдүүлж ажиллах;
- 2.2.2 Мэргэшсэн, тогтвортой хүний нөөцийг бүрдүүлэх;
- 2.2.3 Мэргэжлийн нэр хүнд, үнэ цэнийг хамгаалах;
- 2.2.4 Ёс зүй, харилцаа хандлагыг эрхэмлэж, хариуцлагатай байх;
- 2.2.5 Хүний эрүүл мэнд, хувь хүн, байгууллага, төрийн нууцтай холбоотой мэдээллийн нууцыг чандлан хадгалах;
- 2.2.6 Авлига, албан тушаалын зөрчлөөс ангид байж, урьдчилан сэргийлэх;
- 2.2.7 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд олон улсад болон үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандарт удирдамжийг ашиглаж үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд ханган ажиллах;
- 2.2.8 Манлайлал, хөгжлийг эрхэмлэсэн суралцагч хамт олон байх;
- 2.2.9 Нотолгоонд суурилсан анагаах ухааныг хөгжүүлэх;

ГУРАВ. ТӨВИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Төв нь дараах эрхтэй:

- 3.1.1 Гэмтэл, согог судлалын чиглэлээр улсын хэмжээнд мөрдөгдөх хууль, дүрэм, стандарт, эмнэлзүйн заавар, удирдамжтай холбоотой санал

боловсруулж, нотолгоонд суурилсан мэргэжлийн дүгнэлт гарган, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх санал тавих;

- 3.1.2 Гэмтэл, согог судлалын төрөлжсөн мэргэшлийн оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн заавар, аргачлал боловсруулах, батлуулах, бусад эрүүл мэндийн байгууллагыг мэргэжлийн арга зүйн удирдлагаар хангах;
- 3.1.3 Чанартай тусламж, үйлчилгээг стандартын дагуу хүртээмжтэй үзүүлэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтын асуудлыг төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;
- 3.1.4 Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт зохион байгуулах, орон нутгийн эмч, мэргэжилтнүүдийн ур чадварыг арга хэмжээг зохион байгуулах;
- 3.1.5 Эрүүл мэндийн технологи, оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн заавар, удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, чанар сайжруулах арга аргачлал, хэрэгслийг нэвтрүүлэн тогтмолжуулан ажиллах;
- 3.1.6 Эрдэм шинжилгээ, судалгааны төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, дүн шинжилгээ хийх, үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, сургалт зохион байгуулах; судалгааны үр дүн, ном хэвлэл, заавар зөвлөмжийг боловсруулж хэвлүүлэх, олон нийтэд түгээх;
- 3.1.7 Олон улсын байгууллага, гадаад болон дотоодын ижил чиг үүрэг бүхий байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, судалгаа хийх, туршлага солилцох асуудлаар төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж санамж бичиг байгуулах;
- 3.1.8 Төрийн захиргааны төв байгууллагын баталсан төсвийн хүрээнд санхүүжилт авах, байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах нөөц, төсвийг бүрдүүлэх, зориулалтын дагуу захиран зарцуулах, холбогдох хууль тогтоомжийн дагуу зарим тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлэх;
- 3.1.9 Бусад эрүүл мэндийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, бусад төрийн болон төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ, санамж бичгийг хууль тогтоомжийн хүрээнд байгуулж хэрэгжүүлэх;
- 3.1.10 Монгол Улсад осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдлэг олгох, олон нийтэд зориулсан сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах;
- 3.1.11 Эрүүл мэндийн тухай хууль болон бусад хууль, тогтоомжоор Төвд олгосон бусад эрхийг хэрэгжүүлэх.

3.2 Төв нь дараах үүрэгтэй:

- 3.2.1 Гэмтэл, согогийг оношлох, эмчлэх, сувилах, хөнгөвчлөх, сэргээн засах, лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлэх, бусад эрүүл мэндийн

- байгууллагыг мэргэжлийн арга зүйгээр хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих;
- 3.2.2 Төв нь Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд нийцүүлэн үйл ажиллагаа явуулах, төвийн үйл ажиллагаанд хамаарах дэвшүүлсэн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, салбарын хөгжлийн бодлоготой уялдуулан төвийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэх;
 - 3.2.3 Гэмтэл, согог судлалын төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд чанартай, хүртээмжтэй үзүүлэх;
 - 3.2.4 Осол, гэмтлийн шалтгаант хүн амын өвчлөлийн түвшин, тархалт, нас баралтыг судлах тандалтын тогтолцоо бүхий мэдээллийн сан бүрдүүлж, төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох бусад байгууллагыг мэдээллээр хангах;
 - 3.2.5 Албан хаагчдын нийгмийн баталгаа, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах, мэргэжил ур чадварт тохирсон цалин хөлс олгох, ажлын бүтээмж, үр дүнд суурилсан урамшуулал олгох, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулах;
 - 3.2.6 Албан хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулах, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, хэвшил болгох арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх;
 - 3.2.7 Төвийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд шуурхай хариу өгөх, дүн шинжилгээ хийж хэрэгжилтийг ханган ажиллах;
 - 3.2.8 Гамшиг, онцгой байдал, яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангах, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх нөөц, эрсдэлийн сан бүрдүүлэх;
 - 3.2.9 Барилга байгууламж, эмнэлгийн тоног төхөөрөмж, техник, хэрэгслийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаарх холбогдох хууль, стандартын шаардлагыг ханган ажиллах;
 - 3.2.10 Өөрийн өмчийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, эд хөрөнгийн бүртгэл тооллогыг тогтоосон хугацаанд хийх, данснаас хасах, шилжүүлэх, устгал хийх асуудлыг хууль, журмын дагуу шийдвэрлүүлэх;
 - 3.2.11 Төв нь чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг үндэслэл, тооцоо судалгаанд тулгуурлан боловсруулах, батлагдсан төсөв, орон тооны хязгаарт багтааж, байгууллагын үйл ажиллагааг зохион байгуулах;
 - 3.2.12 Санхүү, төсвийн нээлттэй, ил тод зарчмыг баримтлан Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Шилэн дансны тухай хуулиуд болон бусад холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж, хэрэгжүүлэх;
 - 3.2.13 Үндсэн болон төсөвт хөрөнгийн ашиглалтын зарцуулалт, үр ашгийг дээшлүүлэх, нягтлан бодох бүртгэл, тасаг, алба, нэгжийн аж ахуйн тооцоо, байгууллагын орлого, зарлагын дотоодын хяналт, шалгалтыг тогтмолжуулах;
 - 3.2.14 Төв нь авлига авах, өгөх, албан тушаалын тушаалын байдлаа аливаа хэлбэрээр урвуулан ашиглах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх хууль бус үйлдэл, үйл ажиллагааг хориглох, урьдчилан сэргийлж ажиллах;

- 3.2.15 Жендерийн тэгш байдлыг хангах, ажлын байрны дарамт, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх, хүний эрхэд ээлтэй, аюулгүй орчин бүрдүүлэх.
- 3.2.16 Төвийн зохион байгуулалтын бүтцийн нэгж нь төвийн хууль, тогтоомжоор хүлээсэн үүрэг, дотоод дүрэм, журмыг хэрэгжүүлэх;
- 3.2.17 Эрүүл мэндийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжоор Төвд хүлээлгэсэн бусад үүргийг хэрэгжүүлэх.

ДӨРӨВ. ТӨВИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 4.1 Төвийг Захирал удирдана. Захирал нь Төвийг гадаад, дотоодод төлөөлөх, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах эрхтэй.
- 4.2 Төвийн удирдлагын тогтолцоо нь Захирал, дэд захирлууд болон Удирдлагын зөвлөлөөс бүрдэнэ.
- 4.3 Төв нь Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал, Салбар эмнэлгийн эмнэлзүй эрхэлсэн дэд захирал, Үйл ажиллагаа, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал, Сувилахуй эрхэлсэн дэд захиралтай байна.
- 4.4 Дэд захирлууд нь өөрийн хариуцсан чиг үүргийг Захирлын удирдлага дор хэрэгжүүлж, гүйцэтгэлийн талаар тайлагнаж, хариуцлага хүлээнэ.
- 4.5 Төвийн Захирал нь Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал (2), Үйл ажиллагаа, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал, Сувилахуй эрхэлсэн дэд захирал, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийн албаны дарга, Санхүү, бүртгэлийн албаны дарга, Захиргаа, хүний нөөцийн албаны дарга, Ёс зүйн салбар хорооны төлөөлөл, Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл болон бусад шаардлагатай гишүүдийг оролцуулсан Удирдлагын зөвлөлийг байгуулж, түүний бүрэлдэхүүн, үйл ажиллагааны журмыг батална.
- 4.6 Төв нь эрдэм шинжилгээний ажлын хэтийн болон ойрын зорилт, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, судалгааны үр дүнг хэлэлцэх, үнэлэлт дүгнэлт өгөх үүрэг бүхий Эрдмийн зөвлөлийг ажиллуулна. Эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг холбогдох хууль тогтоомж, тушаал шийдвэр, Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн саналд үндэслэн Захирал батална.
- 4.7 Төвийн захирал тушаал, Удирдлагын зөвлөл болон Эрдмийн зөвлөл нь хурлын шийдвэр, тэмдэглэл гаргана.
- 4.8 Төв нь Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал, шийдвэрийн дагуу Ёс зүйн дэд хороо, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, Эмийн эмчилгээг зохицуулах хороо болон бусад шаардлагатай чиг үүрэг бүхий байнгын, түр хороо, зөвлөлийг байгуулан ажиллуулна.
- 4.9 Төвийн захирлын харьяанд дотоод шалгалт хариуцсан мэргэжилтэн байх бөгөөд хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дотоод хяналт шалгалтыг хараат бусаар зохион байгуулна.
- 4.10 Төвийн зохион байгуулалтын бүтцийн нэгж нь төв, алба, тасаг байна. Нэгжийн удирдлага нь тухайн төв, алба, тасгийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллана.

ТАВ. ГАДААД, ДОТООД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- 5.1. Төвийг гадаад, дотоод хамтын ажиллагаанд Төвийн захирал төлөөлнө.
- 5.2. Захирлын гадаад, дотоод албан томилолтыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар шийдвэрлэнэ.
- 5.3. Захирлын түр эзгүйд түүний албан үүргийг Үйл ажиллагаа, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал хэрэгжүүлнэ. Хэрэв Үйл ажиллагаа, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал эзгүй бол Захирал өөрийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх албан тушаалтныг томилно.
- 5.4. Албан хаагчдыг гадаад, дотоодод албан томилолтоор ажиллуулах, суралцах асуудлыг төвийн захирал шийдвэрлэнэ.
- 5.5. Гадаад орны эрүүл мэндийн байгууллага, төвтэй хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулах замаар төвийн албан хаагчдыг сургах, дадлагажуулах, олон улсын хуралд оролцох, хамтарсан судалгаа хийх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 5.6. Төв нь төрийн захиргааны төв байгууллагаас чиглэл, үүрэг зөвлөмж авч үйл ажиллагаагаа бусад байгууллагатай уялдуулан ажиллана.
- 5.7. Төв нь өөрийн эрхлэх асуудлаар бусад эрүүл мэндийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллага, иргэдтэй шууд харилцана.

ЗУРГАА. ТӨВИЙН САНХҮҮЖИЛТ

- 6.1 Төвийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:
 - 6.1.1 Улсын төсөв
 - 6.1.2 Эрүүл мэндийн даатгалын сан;
 - 6.1.3 Үндсэн (хууль, тогтоомжоор зөвшөөрсөн төлбөртэй тусламж, үйлчилгээний орлого) болон үндсэн бус (хууль, тогтоомжид нийцүүлэн олсон бусад орлого) үйл ажиллагааны орлого;
 - 6.1.4 Төсвийн тухай хуулийн дагуу гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн хандив, тусламж, төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтын орлого;
 - 6.1.5 Хууль, тогтоомжид заасан бусад эх үүсвэр.
- 6.2 Төв нь санхүүжилт, эд хөрөнгийг төвийн зорилго, зорилт, холбогдох хууль, тогтоомж, энэ дүрэмд нийцүүлэн зориулалтын дагуу зарцуулан ашиглаж, ил тод байдлыг хангана.
- 6.3 Төв нь өөрийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үндсэн хөрөнгө бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх, актлах саналаа холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.
- 6.4 Төвийн эд хөрөнгийн тооллогыг Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар тогтоосон хугацаанд, холбогдох журмын дагуу явуулна.
- 6.5 Төв нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу гүйцэтгэж, аудит хийлгэж, аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангана.

- 6.6 Төв нь өөрийн эд хөрөнгө, санхүү, нягтлан бодох бүртгэл, тооцоонд тавих өөрийн болон хөндлөнгийн хяналтыг зохих хууль, тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ.

ДОЛОО.ТӨВИЙН ЗАХИРЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 7.1 Төвийн захирал нь Эрүүл мэндийн сайдтай байгуулсан хөдөлмөрийн гэрээнд зааснаас гадна дараах эрх эдэлнэ. Үүнд:
- 7.2.1 Төвийг удирдаж, зохион байгуулалтаар хангаж, төвийг бүрэн эрхийн хүрээнд төлөөлнө.
 - 7.2.2 Удирдлагын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг баталж, удирдан чиглүүлнэ.
 - 7.2.3 Хууль, тогтоомж болон бусад дүрэм, журмаар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд тушаал, шийдвэр гаргана.
 - 7.2.4 Төвийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл, чиг үүргийг тодорхойлж, байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, ойрын болон хэтийн төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар ханган, хяналт тавина.
 - 7.2.5 Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн эрх зүйн орчин болон хэтийн төлөвлөлттэй уялдуулан төвийн ажилтны тоо, цалин хөлсийг тогтооно.
 - 7.2.6 Дэд захирал, нэгжийн дарга болон ажилтнуудыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу томилж, чөлөөлнө.
 - 7.2.7 Ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг баталж, хөдөлмөрийн гэрээ байгуулж, гүйцэтгэлийг дүгнэж, урамшуулал олгож, сахилгын шийтгэл ногдуулж, гэрээг цуцалж, дуусгавар болгоно.
- 7.3 Төвийн захирал нь Эрүүл мэндийн сайдтай байгуулсан хөдөлмөрийн гэрээнд тусгаснаас гадна дараах үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 7.3.1 Хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг төвийн хэмжээнд зохион байгуулж, үйл ажиллагааны үр дүнг бүрэн хэмжээгээр хариуцна.
 - 7.3.2 Төвийн алсын хараа, хэтийн зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй уялдуулан стратеги төлөвлөгөөг салбарын бодлого, шийдвэртэй нийцүүлэн боловсруулж, батлуулж, хэрэгжүүлнэ.
 - 7.3.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг салбарын урт, дунд, богино хугацааны бодлого болон байгууллагын стратеги төлөвлөгөөтэй уялдуулан батлуулж, хэрэгжилтийг хангаж, хагас болон бүтэн жилээр тайлагнаж, ил тод мэдээлнэ.
 - 7.3.4 Төвийн жил бүрийн төсвийн төслийг нотолгоонд үндэслэн боловсруулж, үйл ажиллагааг удирдлага, арга зүй, зохион байгуулалтаар ханган ажиллана.
 - 7.3.5 Батлагдсан төсөв, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарт багтаан орон тоо, цалингийн санг зохицуулан ажиллана.
 - 7.3.6 Төвийн санхүүгийн үйл ажиллагааг тогтвортой, сахилга баттай, үр ашигтай зохион байгуулж, өр, авлагагүй ажиллана.

- 7.3.7 Үндсэн хөрөнгө болон бараа, материалын зардлын төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавьж, эдийн засгийн үр ашигтай байдлыг хангана.
- 7.3.8 Төвийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх алба, нэгжийн үйл ажиллагааг мэргэжлийн арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавьж, уялдуулан зохицуулна.
- 7.3.9 Төвийн санхүү, төсөв болон бусад үйл ажиллагааны тайлан, мэдээний үнэн зөв байдлыг хариуцна.
- 7.3.10 Төвийн хэмжээнд эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг нэгдсэн удирдлагаар хангана.
- 7.3.11 Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн эрх зүйн орчин болон хэтийн төлөвлөлттэй уялдуулан төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээний цар хүрээ, тоо хэмжээг хүн амын хэрэгцээ, шаардлагад үндэслэн төлөвлөнө.
- 7.3.12 Ажилтны мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшлүүлж, тасралтгүй сургалтад хамруулж, цалин хөлс, нийгмийн баталгааны асуудлаар гаргасан санал, хүсэлтийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
- 7.3.13 Төвийн үйл ажиллагааг сайжруулах санал, арга хэмжээний үр ашгийг тооцож, ашигтай хувилбарыг хэрэгжүүлж, дэмжлэг үзүүлнэ.
- 7.3.14 Удирдах ажилтны ёс зүйг чанд сахиж, үйл ажиллагааны ил тод байдал, жендерийн мэдрэмжтэй байдлыг хангаж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллана.
- 7.3.15 Ажлын байрны дарамт, ёс зүйн зөрчил, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход чиглэсэн арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллана.
- 7.3.16 Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшгийн үед ажиллах шуурхай багийн бүрэлдэхүүн, чиг үүрэг, төлөвлөгөөг тухай бүр тодотгон баталж, шаардлагатай тохиолдолд идэвхжүүлэх ажлыг зохион байгуулна.

НАЙМ.ТӨВИЙН ДЭД ЗАХИРЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 8.1 Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал:
 - 8.1.1 Хариуцсан нэгжүүдийн үйл ажиллагааг нэгдсэн бодлогын удирдлагаар хангаж, гүйцэтгэл, үр дүнг Захирлын өмнө хариуцна.
 - 8.1.2 Үйлчлүүлэгчид эелдэг, шуурхай, хүртээмжтэй тусламж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавина.
 - 8.1.3 Эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх, эмчилгээний стандарт, удирдамжийн мөрдөлт, эмчилгээний чанар, үр дүнг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
 - 8.1.4 Хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолт болон холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг чанд биелүүлж ажиллана.
 - 8.1.5 Гэмтэл, согогийн оношилгоо, эмчилгээний удирдамж, заавар, аргачлал боловсруулах, шинэ технологи нэвтрүүлэх төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн арга зүйгээр хангана.

- 8.1.6 Үйл ажиллагааны тогтвортой байдал, жендерийн тэгш байдал, ялгаварлан гадуурхалт, ажлын байрны дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, авлигаас ангид ажиллах орчныг бүрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавина.
 - 8.1.7 Төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг чанд мөрдүүлж, ил тод, хариуцлагатай соёлыг төлөвшүүлэн ажиллана.
 - 8.1.8 Захирлаас өгсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлж, ажлын хэсэг, нэгжүүдийн уялдаа холбоог ханган ажиллах, арга зүйн дэмжлэг үзүүлж, хяналт тавина.
 - 8.1.9 Гамшгийн үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлөвлөлт, нөөц бүрдүүлэлт, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг зохион байгуулна.
- 8.2 Үйл ажиллагаа, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал:
- 8.2.1 Хариуцсан нэгжүүдийн үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалт, удирдлагаар хангаж, гүйцэтгэл, үр дүнг Захирлын өмнө хариуцна.
 - 8.2.2 Төвийн өдөр тутмын хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангахад шаардлагатай зохион байгуулалтын болон удирдлагын дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавина.
 - 8.2.3 Орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, зардал бууруулах, тоног төхөөрөмжийн ашиглалт, элэгдэл, хэрэглээний судалгаанд тулгуурлан үр ашигтай төлөвлөлт хийх, хэрэгжилтийг зохион байгуулна.
 - 8.2.4 Төвийн жил бүрийн төсвийн төсөл, санхүүжилтийн төлөвлөлтийг нотолгоонд үндэслэн боловсруулах ажлыг удирдлага, арга зүй, зохион байгуулалтаар ханган ажиллана.
 - 8.2.5 Үндсэн хөрөнгө, бараа материалын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлж, эдийн засгийн үр ашгийг хангана.
 - 8.2.6 Гамшгийн үеийн төлөвлөлт, нөөц бүрдүүлэлт, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааг зохион байгуулна.
 - 8.2.7 Үйл ажиллагааны тогтвортой байдал, жендерийн тэгш байдал, ялгаварлан гадуурхалт, ажлын байрны дарамт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, авлигаас ангид орчныг төлөвшүүлэх, хэрэгжилтийг хянана.
 - 8.2.8 Төрийн албан хаагчийн болон мэргэжлийн ёс зүйг чанд мөрдүүлж, ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллана.
 - 8.2.9 Захирлаас өгсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлэх, ажлын хэсэг, нэгжийн уялдаа, зохицуулалтыг хангах, хяналт тавина.
 - 8.2.10 Хөдөлмөрийн гэрээ болон хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргийг биелүүлнэ.
- 8.3 Сувилахуй эрхэлсэн дэд захирлын чиг үүрэг:
- 8.3.1 Улсын хэмжээнд гэмтэл, согогийн сувилахуйн тусламж, үйлчилгээнд мэргэжлийн арга зүйн удирдлага, дэмжлэг үзүүлж, төвийн сувилахуйн тусламж, үйлчилгээг төлөвлөн зохион байгуулж, хэрэгжилтэд тогтмол хяналт, үнэлгээ хийнэ.
 - 8.3.2 Сувилахуйн албыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагааг нь шууд хариуцан удирдан зохион байгуулж ажиллана.

- 8.3.3 Сувилахуйн хүний нөөцийн хэрэгцээг тооцоолох, залгамж халааг тасралтгүй хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 8.3.4 Сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтнүүдийн ур чадвар, мэргэшлийн түвшинд тулгуурласан хөгжлийн хөтөлбөр боловсруулж, өсөлт, дэвшлийг дэмжин ажиллана.
- 8.3.5 Сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтнүүдийн ажлын ачаалал, цагийн менежментийг оновчтой зохион байгуулж, хүний нөөцийг нэгжүүдэд тэнцвэртэй, үр ашигтай хуваарилах, гүйцэтгэлд хяналт тавина.
- 8.3.6 Ёс зүйн дүрэм болон үйлчилгээний стандартыг бүх шатанд мөрдүүлэх, ёс зүйн зөрчил гарах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ил тод, хариуцлагатай байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.
- 8.3.7 Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааны дүн, үнэлгээнд үндэслэн сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлнэ.
- 8.3.8 Шинэ төгсөгч сувилагч болон эмнэлгийн бусад мэргэжилтнийг дадлагажуулах, мэргэшүүлэх сургалт, багц цагийн сургалт болон судалгааны арга зүйн сургалтыг тогтмол зохион байгуулна.
- 8.3.9 Нотолгоонд суурилсан сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, бүтээмжийг дээшлүүлэх бодит арга хэмжээг хэрэгжүүлж, шинэ технологи, инновац нэвтрүүлнэ.
- 8.3.10 Тасаг, нэгжүүдийн уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах, байгууллагын дүрэм, журам, удирдамж, стандартыг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавина.
- 8.3.11 Онцгой болон аюултай нөхцөл байдалд сувилахуйн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажиллах, холбогдох төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ.
- 8.3.12 Авлига, ашиг сонирхлын зөрчил, ялгаварлан гадуурхалт, ажлын байрны дарамт, хүчирхийллээс ангид, хүний эрхэд ээлтэй, жендерийн тэгш байдлыг хангасан ажлын орчныг бүрдүүлнэ.
- 8.3.13 Манлайллыг хөгжүүлэх, инноваци, дэвшилтэт арга барил болон салбар хоорондын сайн туршлагыг нэвтрүүлж, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
- 8.3.14 Хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолт болон холбогдох хууль, тогтоомжоор хүлээсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 8.3.15 Гэмтэл, согогийн сувилахуйн тусламжийн чанарын удирдлагын тогтолцоог хөгжүүлэх, стандарт, удирдамж, зөвлөмж боловсруулах санал гаргах, хэрэгжилтэд хяналт тавина.
- 8.3.16 Сувилахуйн хүний нөөцийн судалгаа, бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлж, бодлого боловсруулах үйл ажиллагаанд мэргэжлийн арга зүйн дэмжлэг үзүүлнэ.
- 8.3.17 Сувилахуйн тусламж, үйлчилгээний чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг зохион байгуулж, үр дүнг дүн шинжилж, бодлогын баримт бичигт тусгуулах санал боловсруулна.
- 8.3.18 Лавлагаа шатлалын сувилахуйн тусламж, үйлчилгээний чиг үүргийн хүрээнд олон улсын байгууллагатай хамтран ажиллаж, дэвшилтэт арга барил, сайн туршлагыг нэвтрүүлнэ.

ЕС.ТӨВИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ ЕРӨНХИЙ ЧИГ ҮҮРЭГ

- 9.1 Төвийн зохион байгуулалтын бүтцийн нэгж нь дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 9.1.1 Холбогдох хууль, тогтоомж, тушаал шийдвэр, стандарт, дүрэм, журмыг хэрэгжүүлэх, мөрдөж ажиллах;
 - 9.1.2 Төрийн албан хаагчийн болон мэргэжлийн ёс зүйг чанд сахиж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах;
 - 9.1.3 Эрхэлсэн чиг үүргийн хүрээнд үйл ажиллагааны үр дүнг захирал, дэд захирлын өмнө хариуцах, тайлагнах;
 - 9.1.4 Хууль, тогтоомжид заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлэх;
- 9.2 **Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэлийн алба:** Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах, эмчилгээ, оношилгоо, эмнэл зүйн шинжилгээний чанарт хяналт тавих, мэргэжил арга зүйгээр хангах, үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 9.3 Төвийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрсдэлийг бүртгэх, эрэмбэлэх, эрсдэлийн шалгуур үзүүлэлтийг батлах, үнэлэх, хариу арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр албан хаагч, үйлчлүүлэгчдэд соён гэгээрүүлэх арга хэмжээ зохион байгуулна.
- 9.4 **Захиргаа, хүний нөөцийн алба:** Төвийн хүний нөөцийн төлөвлөлт, сонгон шалгаруулалт, сургалт, хөгжил, нийгмийн баталгаа, цалин урамшууллын бодлогыг хэрэгжүүлж, архив албан хэрэг хөтлөлт, бодлогын баримт бичиг болон шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж тайланг нэгтгэх, байгууллагын олон нийттэй харилцах болон дотоод, гадаад хамтын ажиллагаа, үйл ажиллагааны ил тод байдлыг зохион байгуулан удирдах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 9.5 **Санхүү, бүртгэлийн алба:** Байгууллагын жилийн төсвийг эдийн засгийн үндэслэлтэйгээр төлөвлөж, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангах, өр, авлагагүй ажиллах, санхүүгийн үйл ажиллагааг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон бусад холбогдох хууль, эрх зүйн актад нийцүүлэн зохион байгуулах, удирдлагыг үнэн зөв, бүрэн мэдээллээр хангах, санхүүгийн тайлан, баланс болон бусад мэдээ, тайланг хуульд заасан хугацаанд гарган тайлагнах, байгууллагын өмч, хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт, зарцуулалтад хяналт тавих, төсвийн ил тод байдлыг хангана.
- 9.6 **Сувилахуйн алба:** Сувилахуйн тусламж, үйлчилгээний нэгдсэн удирдлага, стандарт дүрмийн хэрэгжилт, хүний нөөцийн оновчтой хуваарилалт,

гүйцэтгэлийн хяналт-үнэлгээг ханган ажиллах, сувилахуйн чиглэлээр судалгаа хийж үр дүнг үйлчилгээнд ашиглах, тасаг нэгжүүдийн хамтын ажиллагааг зохион байгуулах, олон улсын төсөл хөтөлбөрт хамтран оролцох, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл болон багц цагийн бүртгэл, хяналтыг хэрэгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- 9.7 **Клиник эм зүйн алба:** Эмийн эмчилгээний үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор эмзүйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаж, чанарын баталгаатай, аюулгүй, эдийн засгийн үр ашигтай эм, урвалж, эмнэлгийн хэрэгслийг тасралтгүй, жигд, хүртээмжтэй ханган нийлүүлж, эмнэлгийн тусламж, үйлчилгээ тасалдахгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ. Халдварт өвчний дэгдэлт, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой нөхцөл байдлын үед шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл болон бусад нөөцийн бэлэн байдлыг, мөн яаралтай тусламжийн эм, хэрэгслийн бэлэн байдлыг хангана. Мөн эмийн жор бичилт, зохистой хэрэглээг төлөвшүүлж, эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх, өвчин үүсгэгчийн эмэнд тэсвэржилтээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж, эмнэлгийн мэргэжилтэн, эмчлүүлэгчийг эмзүйн мэргэжлийн мэдээллээр хангах үйл ажиллагааг зохион байгуулна.
- 9.8 **Халдварын сэргийлэлт, хяналтын алба:** Төвийн онцлогт нийцсэн халдварын сэргийлэлт, хяналтын бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвар (ЭТҮХХ)-ын тандалт, эрт илрүүлэлт, дэгдэлтийн үед авах хариу арга хэмжээ, халдварын эрсдэлийн үнэлгээ, дархлаажуулалт, урьдчилан сэргийлэх шинжилгээ, ариутгал халдваргүйжүүлэлт болон хог хаягдлын менежментэд мэргэжил-арга зүйн удирдлага, хяналт зохион байгуулж, шаардлагатай төсөв санхүүжилтийг тооцон төлөвлөж, холбогдох байгууллагуудтай уялдаа холбоотой ажиллах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 9.9 **Эрүүл мэндийн даатгалын зохицуулалтын алба:** Эрүүл мэндийн даатгалтай холбоотой үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлөвлөн, зохион байгуулах, төвийн нэгжүүдийг мэргэжлийн арга зүйн удирдлагаар хангах, санхүүжилт болон статистик мэдээллийг нэгтгэн тайлагнах, шаардлагатай мэдээллийг шуурхай хүргэх, үзүүлсэн тусламж, үйлчилгээний зардлыг нэхэмжлэх үйл явцыг зохистой хэрэгжүүлэх, эрүүл мэндийн даатгалын тогтолцоог сайжруулах санал боловсруулж ажиллана.
- 9.10 **Нийгмийн эрүүл мэнд, статистикийн алба:** Холбогдох хууль тогтоомж, батлагдсан журам, арга аргачлалыг баримтлан тус төвийн тусламж үзүүлсэн осол гэмтлийн өвчлөлийн өгөгдлийн сан бүрдүүлэлтэд хяналт тавьж, түүнээс өдөр тутмын болон сарын мэдээ, улирал, жилийн тайлан, үйл ажиллагааны статистик үзүүлэлтийг тооцон гаргаж, байгууллагын төлөвлөлт, тайлагналт зэрэг үйл ажиллагааг мэдээллээр хангах, яаралтай тусламж үзүүлсэн үйлчлүүлэгчдийн цахим мэдээллийн сан бүрдүүлэлтэд оролцож, осол гэмтлийн чиглэлээр тандалт, судалгаа хийх, урьдчилан

- сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах, хүчирхийлэлд өртөгсдөд сэтгэл зүйн болон эрүүл мэндийн нэг цэгийн цогц тусламж үйлчилгээ үзүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.
- 9.11 **Эрдэм шинжилгээ, сургалтын алба:** Гэмтэл, согогийн чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний ажил эрхлэх, судалгааны дүн, зөвлөмж боловсруулах, олон улсын анагаах ухааны ололт амжилтыг нутагшуулах, санал, зөвлөмж боловсруулах, салбарын дотоод, гадаад төгсөлтийн дараах сургалтын удирдамж, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж зохион байгуулах, мэдээ мэдээллийн сан бүрдүүлэх, гадаад харилцааны бодлогыг тодорхойлж, олон улсын байгууллагуудтай үр ашигтай хамтран ажиллах, гэрээ хэлцлийн төслүүдийг боловсруулан хэрэгжүүлэх, олон улсын хурал, сургалт, семинар, төсөл хөтөлбөрт оролцох болон зохион байгуулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 9.12 **Мэдээлэл технологийн алба:** Хууль, дүрэм, стратегид нийцүүлэн мэдээллийн аюулгүй байдал, кибер хамгаалалт, өгөгдөл хадгалалт болон цахим системийн тасралтгүй ажиллагааг хангаж, нэгдсэн мэдээллийн систем, телемедицин болон бусад цахим үйлчилгээг хөгжүүлэн уялдуулж, дэвшилтэт технологид суурилсан өгөгдлийн дүн шинжилгээ хийж, удирдлагын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх, мэдээллийн технологийн дэд бүтэц, программ хангамжийн шинэчлэл, инновацыг хэрэгжүүлж, мэдээллийн технологийн стандарт, нууцлал, мэдээллийн урсгалын зохион байгуулалт болон ажилтнуудын кибер орчны зөв хэрэглээ, цахим систем ашиглах ур чадварыг дээшлүүлэх сургалт, дэмжлэгийг зохион байгуулан байгууллагын үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 9.13 **Тоног төхөөрөмжийн алба:** Төв болон салбар эмнэлгийн эмчилгээ, оношилгооны тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангаж, техникийн паспорт, цаг бүртгэлийг хөтлөх, сэлбэг хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, засвар үйлчилгээ болон эрсдэлийн үнэлгээг холбогдох стандартын дагуу хэрэгжүүлнэ. Мөн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, ашиглалтын зааварчилгаа, сургалтыг зохион байгуулж, судалгаа хийх, шинэ технологи нэвтрүүлэх, техникийн тодорхойлолт боловсруулах ажлыг гүйцэтгэнэ. Холбогдох сайдын тушаалын дагуу тоног төхөөрөмжийг актлах, тоног төхөөрөмжийн төсвийн төслийг боловсруулах, шалгалт тохируулгад тогтмол хамруулах үйл ажиллагааг мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулна.
- 9.14 **Дэмжих үйлчилгээний алба:** Дэмжих үйлчилгээний алба нь төв болон салбар эмнэлгийн барилга байгууламж, инженерийн дэд бүтэц, дулаан, цахилгаан, усан хангамж, агааржуулалт, зам талбай, ногоон байгууламж, түргэн тусламжийн автомашины бүрэн бүтэн хэвийн, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж, үзлэг шалгалт, засвар үйлчилгээ, эрсдэлийн

үнэлгээ, сэлбэгийн нөөц бүрдүүлэлт, техникийн бүртгэл хөтлөлт, галын болон бусад бэлэн байдлыг ханган ажиллах, барилга байгууламжийн засвар шинэчлэлд хяналт тавих, инженерийн системийн хэмнэлт, урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний хэрэгжилт болон дэд бүтцийг сайжруулах шинэ технологи, шийдлүүдийг стандартын дагуу зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- 9.15 **Хоол эмчилгээний алба:** Ажилтан, үйлчлүүлэгч, өвчтөнүүдийг баталгаатай, эрүүл, шаардлага хангасан хүнсээр хангаж, хоол үйлдвэрлэлийг технологийн карт, стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагын дагуу зохион байгуулан хэрэгжүүлэх, түүхий эдийн чанар, хадгалалт, хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих, өвчтөн болон асран хамгаалагчдад хоол зүй, зөв хооллолтын зөвлөгөө өгөх, эмчилгээний дэглэмийн дагуу хоол үйлдвэрлэл, хүргэлтийн үйлчилгээг мэргэжлийн түвшинд гүйцэтгэх, шинэ технологи, олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэх судалгаа хийх, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээнд үндэслэн хоол эмчилгээ, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 9.16 **Лабораторийн нэгдсэн тасаг:** Био аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах, цус болон цусан бүтээгдэхүүн сэлбэснээс үүдэлтэй урвал, хүндрэлийг бүртгэж мэдээлэх, шинжилгээ болон тоног төхөөрөмжийн стандарт ажиллагааны заавар боловсруулан мөрдөх, шинжилгээний явцад тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг тогтмол ханган ажиллах, шинжилгээний хариу болон аюултай болон сэрэмжлүүлэх хариуг холбогдох журмын дагуу цаг хугацаанд нь мэдээлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 9.17 **Дүрс оношилгооны тасаг:** Гэмтэл, согогийн бүх төрлийн дүрс оношилгооны шинжилгээг батлагдсан удирдамж, стандартын дагуу чанартай гүйцэтгэж, шинэ технологийн хэрэгцээ шаардлагыг судлан удирдлагад танилцуулах тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг ханган зөв ашиглах, үйлчлүүлэгчийн чирэгдэлгүй үйлчилгээг зохион байгуулж ачааллыг тэнцвэржүүлэх, туяаны хамгаалалтыг мөрдөх, шинжилгээний дүгнэлтийг холбогдох журмын дагуу бичиж мэдээлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 9.18 **Яаралтай тусламжийн тасаг:** Улсын хэмжээнд харьяалал үл харгалзан яаралтай тусламж, үйлчилгээг цогц байдлаар үзүүлж, тоног төхөөрөмж, ажиллах хүч, техник, хэрэгслийн 24 цагийн бэлэн байдлыг ханган ажиллаж, хүчирхийлэлд өртсөн иргэнд нэг цэгийн үйлчилгээ үзүүлж холбогдох байгууллагад мэдэгдэн холбон зуучлах, мөн яаралтай тусламжийн чиглэлээр анагаах ухааны шинэ ололт, амжилтыг нэвтрүүлэн хэрэгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 9.19 **Мэс засал, мэдээгүйжүүлгийн нэгдсэн тасаг:** Мэс засал, мэдээгүйжүүлгийн нэгдсэн тасаг нь нэн яаралтай, яаралтай болон

- төлөвлөгөөт мэс заслын тусламж, үйлчилгээг үзүүлж мэс заслын үеийн мэдээгүйжүүлгийн зохистой менежмент, мэс заслын өмнөх болон дараах өвдөлт намдаах тусламж, үйлчилгээг мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 9.20 **Амбулаторийн тасаг:** Гэмтэл, согогийн чиглэлээр амбулаторийн оношилгоо, шинжилгээ, эмчилгээ болон тусламж, үйлчилгээг үзүүлж иргэдэд шуурхай, чирэгдэлгүй, хүртээмжтэй, жигд үйлчлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ. Хэвтэн эмчлүүлэх (төлөвлөгөөт) хэсгийг хариуцан ажиллана.
- 9.21 **Сэргээн засах, уламжлалт эмчилгээний тасаг:** Согог, осол гэмтэл, мэс засал болон түүний дараах үеийн үлдцийн улмаас үүссэн үйл ажиллагааны чадвар алдагдлыг сэргээж, үйлчлүүлэгчдэд сэргээн засах тусламж, үйлчилгээг үзүүлнэ. Сэргээн засахын их эмч, хөдөлмөр засалч, хөдөлгөөн засалч, сэтгэл зүйч, уламжлалтын эмч, сувилагч зэрэг олон мэргэжилтнээс бүрдсэн багаар орчин үеийн дэвшилтэт арга, технологийг ашиглан батлагдсан стандарт, удирдамжийн дагуу тусламж, үйлчилгээг зохион байгуулж хэрэгжүүлнэ. Уламжлалт анагаах ухааны эмчилгээ, үйлчилгээтэй хослуулан зүү эмчилгээ, төөнө эмчилгээ болон бусад уламжлалт эмчилгээг хэрэгжүүлнэ. Шаардлагатай тохиолдолд (хүчирхийлэлд өртсөн, амиа хорлох оролдлого, эрхтэн тайруулсан, гэмтлийн дараах цочрол) үйлчлүүлэгч, тэдний ар гэр, мөн эмч, эмнэлгийн ажилтнуудад сэтгэц, сэтгэл зүйн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
- 9.22 **Толгойн мэс заслын тасаг:** Гавал, тархи, нүдний ухархай, чих, хамар, хоолой, эрүү-нүүрний гэмтлийн үед үзүүлэх тусламж, үйлчилгээг түргэн шуурхай үзүүлнэ.
- 9.23 **Хавсарсан гэмтлийн мэс заслын тасаг:** Цээж, хэвлийн хөндийн эрхтний гэмтэл, аарцгийн ясны гэмтэл болон хавсарсан, хам гэмтэлтэй үйлчлүүлэгчдэд осол, гэмтлийн үеийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
- 9.24 **Нурууны мэс заслын тасаг:** Хүзүү, нуруу, нугасны гэмтэл, согогийн үед осол, гэмтлийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
- 9.25 **Гар, сарвууны мэс заслын тасаг:** Дээд мөчний согог, гар, сарвууны гэмтлийн үед мэс заслын болон нөхөн сэргээх тусламж, үйлчилгээг үзүүлнэ.
- 9.26 **Хүүхдийн мэс заслын тасаг:** Хүүхдийн гэмтэл, согог, осол гэмтлийн үед үзүүлэх тусламж, үйлчилгээг түргэн шуурхай үзүүлнэ.
- 9.27 **Насанд хүрэгчдийн мэс заслын тасаг:** Насанд хүрэгчдийн доод мөчдийн гэмтэл, согогийн үед үзүүлэх тусламж, үйлчилгээг хэрэгжүүлнэ.
- 9.28 **Эрчимт эмчилгээний тасаг:** Осол, гэмтлийн үед нэн яаралтай болон яаралтай мэс засалд орсон, амь тэнссэн, хавсарсан хүнд гэмтэлтэй, маш

хүнд, хүнд, хүндэвтэр өвчтөнд эрчимт эмчилгээний тусламж, үйлчилгээг үзүүлнэ. Тусламж, үйлчилгээг батлагдсан стандарт технологи, эмнэлзүйн заавар, удирдамжийн дагуу зохион байгуулж хэрэгжүүлнэ.

9.29 **Салбар эмнэлэг** нь дараах зохион байгуулалтын бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулна. Оношилгоо, шинжилгээ, эмчилгээний батлагдсан стандарт технологи, эмнэлзүйн заавар, удирдамжийн дагуу тусламж, үйлчилгээг зохион байгуулж хэрэгжүүлнэ. Үүнд:

- 9.29.1 Түлэгдэлтийн төв;
- 9.29.2 Спортын гэмтлийн төв
- 9.29.3 Ясны эмгэгийн мэс заслын тасаг
- 9.29.4 Нөхөн сэргээх мэс заслын тасаг
- 9.29.5 Сэргээн засах, уламжлалт эмчилгээний тасаг
- 9.29.6 Эрчимт эмчилгээний тасаг
- 9.29.7 Яаралтай тусламжийн тасаг
- 9.29.8 Мэс засал, мэдээгүйжүүлгийн тасаг
- 9.29.9 Амбулаторийн тасаг

9.30 **Түлэгдэлтийн төв:** Улсын хэмжээнд түлэгдэлт, хөлдөлт, осголт, сэдрэлтэй гэмтлийн үед тусламж, үйлчилгээг цогцоор нь үзүүлнэ. Мөн усанд живсэн, амьтанд хазуулсан, шавжид хатгуулсан болон гэмтэл, бэртлийн дараах халдварлагдсан шарх, шархлаатай тохиолдолд лавлагаа шатлалын төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

9.31 **Спортын гэмтлийн төв:** Улсын хэмжээнд бүх төрлийн спортын гэмтлийн үед мэс засал болон сэргээн засах тусламж, үйлчилгээг лавлагаа шатны төрөлжсөн мэргэшлийн түвшинд цогцоор нь үзүүлнэ.

9.32 **Ясны эмгэгийн мэс заслын тасаг:** Улсын хэмжээнд бүх төрлийн ясны гэмтэл, ясны эмгэг, согог, ясны хавдрын үед мэс заслын тусламж, үйлчилгээг лавлагаа шатны төрөлжсөн мэргэшлийн түвшинд цогцоор нь үзүүлнэ.

9.33 **Нөхөн сэргээх мэс заслын тасаг:** Улсын хэмжээнд бүх төрлийн олдмол болон төрөлхийн гажиг, согог, гэмтэл, бэртлийн дараах зөөлөн эдийн дутмагшил, түлэгдэлт, хөлдөлтийн дараах сорвижилтын үед нөхөн сэргээх, гоо сайхны болон бүтэц, үйл ажиллагааг сайжруулах мэс заслын тусламж, үйлчилгээг лавлагаа шатны төрөлжсөн мэргэшлийн түвшинд үзүүлнэ.

9.34 **Зөвлөл, хороод:** Төв нь Удирдлагын зөвлөл, Эрдмийн зөвлөл, Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн алба, Ёс зүйн дэд хорооноос гадна дараах орон тооны бус зөвлөл, хороо, дэд хороодтой байна. Үүнд:

Эмнэлзүйн хороо нь эмнэлгийн мэргэшлийн багийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг хянах, удирдлагаар хангах, санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, алба, тасаг, нэгжүүд болон хороодын үйл ажиллагааг уялдуулах, тасралтгүй чанартай тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Цус, цусан бүтээгдэхүүний дэд хороо нь цус, цусан бүтээгдэхүүний захиалга, хадгалалтын горим, зохистой хэрэглээ, нөөцийн удирдлага, үл тохирол, алдаа, сургалт, сурталчилгаатай холбоотой үйл ажиллагааг зохицуулна.

Эмийн эмчилгээний хороо нь эм, эмнэлгийн хэрэгслийн хэрэгцээ, захиалга, төсөв, үнийн санал, нөөцийн удирдлага, эмийн хордлого, мэдээлэл, зохистой хэрэглээ, сургалт, сурталчилгаа, эмийн сангийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Хоолны чанарын дэд хороо нь эмчилгээний хоол, үйлчилгээний зохион байгуулалт, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тасгийн стандарт, журмын мөрдөлтийг хянах, эмчилгээний хоолны нэр төрөл, чанар, технологийн гүйцэтгэл, хүнсний бүтээгдэхүүний худалдан авалт, чанар, хадгалалтад хяналт тавих, эмч, үйлчлүүлэгчдийн эмчилгээний хоолны талаарх мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагааг зохицуулна.

Хүний нөөцийн хороо нь салбарын хүний нөөцийн хууль, журамд нийцүүлэн хүний нөөцийн төлөвлөлт, хэрэгжилт, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, цалин, урамшуулал, нийгмийн баталгааг хангах үйл ажиллагааг зохицуулна.

Хөдөлмөрийн аюулгүй байдлын дэд хороо нь хөдөлмөрийн аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих, эрсдэлийн үнэлгээ хийж, хариу арга хэмжээ авах, хөдөлмөрийн аюулгүй байдлын зөрчлийг шийдвэрлэх, норм, норматив тогтоох үйл ажиллагааг зохицуулна.

Эрсдэлийн удирдлагын хороо нь байгууллагын зорилго, зорилтод хүрэх явцад гарч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, хянах, удирдах, гэнэтийн эрсдэл үүсэх нөхцөлд санхүү, хүний нөөцийн байдлаа хамгаалах, төлөвлөх, хохирол багатайгаар даван туулах үйл ажиллагааг зохицуулна.

Үйлчлүүлэгчдийн зөвлөл нь үйлчлүүлэгч болон түүний ар гэрээс эмнэлгийн үйлчилгээний талаарх санал, сэтгэгдлийг сонсож, хэрэгцээг тодорхойлох, тэдгээрийг эмнэлгийн удирдлага, ажилтнуудад танилцуулж, төлөвлөлт, сайжруулалтын үйл ажиллагаанд тусгуулах ажлыг зохицуулна.

АРАВ. БУСАД ЗҮЙЛ

- 10.1. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санаачилга болон салбарын хөгжлийн бодлого, чиглэлтэй уялдуулан энэхүү дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулна.
- 10.2. Төвийн саналыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын тушаалаар энэхүү дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 10.3. Энэхүү дүрэм нь Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсанаар хүчин төгөлдөр болно.
- 10.4. Төвийн дүрэм хүчин төгөлдөр болж үйлчилж эхэлснээр Төвийн нийт албан хаагчид дагаж мөрдөнө.
- 10.5. Энэхүү дүрэмд тусгагдаагүй бусад асуудлыг холбогдох хууль, тогтоомж болон эрх зүйн баримт бичгээр зохицуулна.

ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

